**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ**

2018 оны 07 сарын 03 өдөр Дугаар 327 Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин
зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 15,555,560.00 (арван таван сая таван зуун тавин таван мянга таван зуун жаран) төгрөгийн балансын үнэ бүхий суудлын автомашины дуудлагын худалдааг дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.“Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ө.Оюунбаатарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу төрийн өмчит үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Б.Гаваа Б.ГАВАА

D:\Huraldaanii material\2018 on\2018.07.03Togtool.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн
327 дугаар тогтоолын хавсралт

**"ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ДАХИН ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ**

| Д/д | Суудлын автомашины марк, улсын дугаар | Үйлдвэрлэсэн/ Ашиглалтад орсон он | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | Худалдах доод үнэ (төгрөг) | Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Суудлын автомашин Делика мицубиши, УБХ 43-25, арлын дугаар PD6W1002524 | 2010/2012 | 15,555,560.00 | 10,076,547.30 | 5,479,012.70 | 6,000,000.00 | 4,000,000.00 |
| | **Нийт дүн** | | **15,555,560.00** | **10,076,547.30** | **5,479,012.70** | **6,000,000.00** | **4,000,000.00** |
| | | | (арван таван сая таван зуун тавин таван мянга таван зуун жаран) | (арван сая далан зургаан мянга таван зуун дөчин долоон төгрөг гучин мөнгө) | (таван сая дөрвөн зуун далан есөн мянга арван хоёр төгрөг далан мөнгө) | (зургаан сая) | (дөрвөн сая) |